

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НИЙГМИЙН
САЛБАР, НОГООН ХӨГЖИЛ БОЛОН АГААР,
ОРЧНЫ БОХИРДЛЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ОРЛОГЧ, "НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН БАЯР-ХҮРЭЭ ЦАМ ДАНШИГ
НААДАМ 2025"-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА

А.АМАРТҮВШИН

2025 оны 06 дугаар сарын 09

УДИРДАМЖ

2025 оны 06 дугаар сарын 09...

Улаанбаатар хот

"НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН БАЯР-ХҮРЭЭ ЦАМ ДАНШИГ НААДАМ 2025"-ЫН
ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Нэг.Зорилго:

1.1."Нийслэлийн иргэдийн баяр-Хүрээ цам даншиг наадам-2025" наадмын үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэхүү удирдамжийн зорилго оршино.

Хоёр."Нийслэлийн иргэдийн баяр-Хүрээ цам даншиг наадам-2025" наадмын үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулах газар, хугацаа:

2.1.Үндэсний бөхийн барилдааныг 2025 оны 06 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд Улаанбаатар хотын Хүй долоон худаг, Монгол наадам цогцолборын төв талбайд зохион байгуулна.

2.2.Монголын үндэсний бөхийн холбооноос бөхийн барилдааныг зохион байгуулах жаяг дэгийн баг (гарын даа, ерөнхий цэц, хөлийн цэц, засуул, бөх тайлбарлагч, хаяавч, эмч)-ийг томилон ажиллуулна.

2.3.Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын үндэсний бөхийн холбоотой хамтран бөх барилдах талбайг урьдчилан бэлдэж шаардагдах хэрэглэлийг байрлуулж зохион байгуулалтын бусад ажлыг хангаж ажиллана.

Гурав.Бөхийн барилдаан:

3.1."Нийслэлийн иргэдийн баяр-Хүрээ цам даншиг наадам-2025" наадамд 256 бөх "Үндэсний бөхийн барилдааны дүрэм"-ээр барилдана.

3.2.Үндэсний бөхийн барилдааны нэгийн давааг 2025 оны 06 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулна.

3.3.Үндэсний бөхийн барилдаан 2025 оны 06 дугаар сарын 29-ний өдөр хоёрын даваанаас эхлэн үргэлжилнэ.

3.4.Үндэсний бөхийн барилдаанд барилдах бөх “Үндэсний бөхийн барилдааны дүрэм”-ийн дагуу авсан цолны эрэмбээр зүүн, баруун жигүүрийг манлайлан барилдаж, цолоо дуудуулна.

3.5.Үндэсний бөхийн барилдаанд ямар нэгэн цол, чимэг олгохгүй.

Дөрөв.Бөхчүүдэд тавигдах шаардлага:

4.1.Үндэсний бөхийн барилдааны бүртгэлийг 2025 оны 06 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд “Дэвжээ.мн” сайтаар цахимаар бүртгэж Монгол үндэсний бөхийг 256 бөхөөр бүртгэлийг тасалбар болгож хаана. Бүртгэлд хамрагдсан бөхчүүдэд 06 дугаар сарын 27-ны өдөр 12:00-17:00 цагийн хооронд Монгол бөхийн өргөөнд мандат олгоно.

4.2.Гарын даа, ерөнхий цэц, дэд цэц, хөлийн цэц, засуулуудын тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу ёс зүйгүй авир, үйлдэл гаргасан бөхийг тухайн барилдаанаас шууд хасаж учраа бөхийг давсанд тооцно.

Тав.Бөхчүүдэд олгох шагнал, урамшуулал:

5.1.Бөхийн барилдаанд түрүүлсэн бөхөд алтан медаль, үзүүрлэсэн бөхөд мөнгөн медаль, их шөвөгт үлдсэн бөхчүүдэд хүрэл медаль олгоно.

5.2.Үндэсний бөхийн барилдаанд 1, 2, 3, 4 давсан, шөвгөрсөн бөхчүүдэд дор дурдагдсан мөнгөн шагналыг олгоно.

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт дүн /төгрөг/
1.Үндэсний бөхийн барилдаан				
1.1.	Түрүүлсэн бөх	1 бөх	30,000,000	30,000,000
1.2.	Үзүүрлэсэн бөх	1 бөх	20,000,000	20,000,000
1.3.	Их шөвөг	2 бөх	10,000,000	20,000,000
1.4.	Дунд шөвөг	4 бөх	3,000,000	12,000,000
1.5.	4 давсан бөх	8 бөх	800,000	6,400,000
1.6.	3 давсан бөх	16 бөх	500,000	8,000,000
1.7.	2 давсан бөх	32 бөх	200,000	6,400,000
1.8.	1 давсан бөх	64 бөх	150,000	9,600,000
Дүн:				124,400,000

“НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН БАЯР-ХҮРЭЭ ЦАМ ДАНШИГ НААДАМ 2025”-ЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ